



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 82 ХУВЬТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/06-01-ШТА-НА

Архангай аймаг 2025 он



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Аудитор Н.Дашмягмар

Утас: 99164656 Цахим хаяг: Dashmyagmam@audit.gov.mn



Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар		➤ Товчилсон үгийн тайлбар 3-4 ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 5-7 ➤ Үндсэн мэдээлэл 7 ➤ Аудитын тайлан 8-21
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа	БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА.	
Аудитын менежер Д.Нэргүйбаатар	А.1. Аймгийн хэмжээнд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-нь улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан харин 10.7 хувь нь аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.	
Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ	А.2 Улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 57.1 хувийн ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг орон нутагт үнэлэх боломжгүй байна.	
Аудитор Н.Дашмягмар	А.3 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 11 ТАХ-г магадлалаар хянаж төсөвт өртгийг 7,281.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.	
2025 оны 04 дүгээр сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү.	А.4 Шинээр хэрэгжих ТАХ нь Төрийн хэмнэлтийн хуульд нийцсэн, тухайн шатны хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөсөн байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу	БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН БАЙНА.	
Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	Б.1. Аймгийн хэмжээнд улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих ТАХ-ний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92.8 хувьтай байна.	
	Б.2 Шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний 96.2 хувийн тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, баталсан байна.	
	Б.3 Тендерийн баримт бичигт тусгасан шаардлага хангаагүй этгээдээр 303.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламжийн ажлыг гүйцэтгүүлэхээр шалгаруулсан байна.	
	БҮЛЭГ В. УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТУХАЙН ОНД ХЭРЭГЖҮҮЛЖ ДУУСАХААР ТӨЛӨВЛӨСӨН 17 ТАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТ 76.5 ХУВЬТАЙ БАЙНА	
	В.1. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг бүрэн хянаагүйн улмаас бодит гүйцэтгэлээс 829.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна. .	
	В.2. Аймгийн хэмжээнд 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн ТАХ-ний 23.5 хувийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, гэрээ дүгнээгүй байна.	
	В.3. Тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн ТАХ-ний 15.4 хувь буюу 2 барилга байгууламжийг ТЭЗҮ, зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байна.	
	В.4. Тайлант онд байнгын ашиглалтад хүлээн авсан ТАХ-г зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа боловч 20,923.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна.	
	Дүгнэлт..... 22	
	Зөвлөмж 23	
Холбогдох байгууллагын санал 24		
Тайлан баталгаажуулсан тушаал..... 25-26		
Хавсралт:Судалгаанууд 26-34		



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
БОУАӨС	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД
БС	БОЛОВСРОЛЫН САЙД
ХББОСС	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД
ББАОК	БАРИЛГА БАЙГУУЛАМЖ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИСС
НА	НИЙЦЛИЙН АУДИТ
ГАГ	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
ГХБХБГ	ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
ЗГХЭГ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ЗТС	ЗАМ ТЭЭВРИЙН САЙД
НТШ	НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ
ОНӨГ	ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
СТСХ	САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС
СХАА	САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА
ТАХ	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ХААГ	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
ХХААХҮС	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
ХОХБТХ	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС
ЭМГ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ЭМС	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ЭХС	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Бодлогын баримт бичиг	11
2	Нээлттэй тендер шалгаруулалт	13
3	Харьцуулалтын арга	13
4	Нийт олгосон санхүүжилтийн хуваарилалт	16

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар олгох санхүүжилт, гүйцэтгэлээр олгосон санхүүжилт, барьцаанд төвлөрүүлсэн байдал	7
2	2024 оны Төсвийн хуулиар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний жагсаалт ба ТЕЗ-аас хүргүүлсэн саналын судалгаа	9
3	Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналыг харьяа яамдын Сайдын багцад хуваарилсан ТАХ	9
4	Харьяа яамны Сайдаас эрх шилжүүлсэн ТАХ	10



5	Шинээр хэрэгжих 21 барилга байгууламжийн төлөвлөлтийн шаардлага хангасан байдал	
6	Шинээр хэрэгжих барилга байгууламжид олгосон газрын зөвшөөрөл	11
7	Аймгийн хэмжээнд 2024 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа	12
8	ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилсан судалгаа	
9	Магадлалын ерөнхий дүгнэлтээр төсөв нь нэмэгдсэн ТАХ-ний жагсаалт	
10	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний ангилал, гэрээний хугацаанд хэрэгжээгүй ТАХ-ний тоо, гэрээний дүн	17
11	Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй ТАХ, гэрээний дүн	20
12	Өмнөх аудитаар шалгагдагч байгууллагад хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт /хувиар/	21



АУДИТЫН НЭР:

“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/06-ШТА-НА

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” МҮЕА-ын 2024 оны А/108 дугаар тушаал, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан нийцлийн аудитын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар Архангай аймагт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх;

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад Архангай аймагт 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ болон СТСХ, ХОХБТХ, аймгийн ГХБХБГ, ХААГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамрууллаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, МҮЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, түүвэрлэлт хийх, тулган баталгаажуулах, судалгаа авч нэгтгэх зэрэг Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан төлөвлөгөөний арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

✓ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, ГНАГ-2025/06-01-ШТА-НА



- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тухай хууль,
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- ✓ Барилгын тухай хууль,
- ✓ Авто замын тухай хууль,
- ✓ Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- ✓ Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”,
- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”,
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
- ✓ Архангай аймгийн ИТХ-ын тогтоолууд
- ✓ Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
- ✓ Архангай аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- ✓ Архангай аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө,
- ✓ Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжүүд,
- ✓ Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор Н.Дашмягмар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2025.03.06-2025.04.18-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.

Нийцлийн аудитын тайланг асуудлын шинжилгээний 3 дахь түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 2 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичсэн болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Архангай аймагт хэрэгжүүлэхээр өмнөх оноос он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй 157,767.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээг 48,839.6 сая төгрөгөөр, шинээр 64,933.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 арга хэмжээг 27,280.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. /Эх сурвалж: 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр өөрчлөн найруулж баталсан Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт/



Тайлант жилд сайдуудын багцаас аймгийн Засаг даргад шинээр болон өмнөх оноос үргэлжлүүлэх нийт 39 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж **76,120.0** сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор төлөвлөснөөс 56,277.4 сая төгрөгийг аймгийн төрийн санд шилжүүлсэн байна. Төрийн сангаас ажлын гүйцэтгэлд үндэслэн **50,547.5** сая төгрөгийг гүйцэтгэгч нарт олгож, 5,729.9 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар олгох санхүүжилт, гүйцэтгэл, барьцаа хөрөнгийн дансны судалгаа

Хүснэгт 1. /сая.төгрөг/

№	Харьяа Сайд	Хэрэгжсэн ТАХ-ний тоо	Улсын төсвөөс 2024 онд олгох санхүүжилт	Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт	Барьцаа хөрөнгийн дансанд
1	ЗТХСайд	6	38,095.8	31,932.5	261.6
2	Боловсролын Сайд	15	18,610.2	13,357.0	1,222.3
3	ХХААХҮС	2	1,700.0	835.8	848.7
4	ГБХНХС	1	150.0	126.5	-
5	ХББОСС	2	5,950.0	838.9	19.3
6	ЭХСайд	2	448.0	393.5	12.9
7	ССАЖЗС	6	7,182.8	1,575.9	3,326.6
8	ЗГХЭГ	5	3,983.2	1,487.4	38.5
Нийт дүн		39	76,120.0	50,547.5	5,729.9

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 249 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/920 дугаар захирамжаар 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдэл болох **5,729.9** сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ. / Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 06/273 дугаар албан бичиг/

Харин аймгийн Засаг даргад эрх шилжүүлээгүй шинээр болон өмнөх оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 128,663.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй **20** ТАХ-г 58,157.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Тайланд онд 45,677.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй **7** төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Үлдэх 82,985.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй **13** төсөл, арга хэмжээ нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу дараа онд үргэлжлүүлэхээр байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаар: Өмнөх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт **58,128.1** сая төгрөгийн зөрчил илэрч **6.7** сая төгрөгийн төлбөрийн акт, **58,121.4** сая төгрөгийн зөрчилд **6** албан шаардлага, **2** заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүлж шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан ажилласан. Энэ аудитаар зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг үнэлэв.



А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА.

А.1. Аймгийн хэмжээнд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ- нь улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан харин 10.7 хувь нь аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ны 52 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ыг 9 зорилго 73 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр баталсан байна. Тус бодлогын баримт бичиг тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд дунд болон богино хугацааны баримт бичгүүд түүний уялдааг хангаж ажиллахыг Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заажээ.

Дүрслэл 1: Бодлогын баримт бичиг



УИХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Монгол улсын 2024 оны Төсвийн тухай хуулийг баталсны дагуу Аймгийн ИТХ-ийн 2023 оны 12 дугаар сарын 01-ны 07 дугаар тогтоолоор "Архангай аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө"-г баталсан байна. Хууль батлагдсаны дараа аймгийн ТЕЗ нь дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулсан боловч төсвийн хуульд тусгагдсан 548.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-г 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусган батлуулаагүй нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.14¹, 5.2.3², 5.1.12³ дахь заалтуудтай нийцээгүй байна.

Тухайлбал:

1. ЗГХЭГ-аас эрх шилжсэн V.3.1.1 хуулийн дугаартай 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Аймаг, сумын тоног төхөөрөмж" төсөл,
2. ЭХЯ-аас эрх шилсэн XX.1.39 хуулийн дугаартай 144.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын төвийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэлт" төсөл, /Ихтамир сум/

¹ 4.1.14 "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг;

² 5.2.3 "нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээлэл, аргачлал нь нэгдмэл, уялдаатай байж, бодлогыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг;

³ 5.2.12 "төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим" гэж "дээрээс доош" төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, "доороос дээш" төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг;



3. ЭХЯ-аас эрх шилсэн ХХ.1.39 хуулийн дугаартай 303.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын төвийн цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж" төсөл, /Цэцэрлэг Хашаат сумдад/

А.2 Улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 57.1 хувийн ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг орон нутагт үнэлэх боломжгүй байна.

Архангай аймгийн Засаг даргаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх 37 төсөл арга хэмжээний саналыг боловсруулж аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож жагсаалтыг 2023 онд СЯ-нд хүргүүлж, хөрөнгө оруулалтын www.pimis.mn цахим системээр үнэлсэн байна.

2024 оны Төсвийн хуулиар шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ болон ТЕЗ-аас хүргүүлсэн саналын судалгаа

Хүснэгт 2. /сая.төгрөг/

№	Хуулийн код	ТЕЗ	Төсвийн хуулиар батлагдсан шинээр хэрэгжих ТАХ-д			ТЕЗ-аас сангийн яаманд хүргүүлсэн ТАХ-д			Тайлбар
			Тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	
1	V	ЗГХЭГ	4	7,461.7	3,781.0	5	15,500.0	7,000.0	ТЕЗ-аас хүргүүлсэн саналаас 12 ТАХ-г төсвийн хуулиар оруулан баталсан. Бусад арга хэмжээ дэмжигдээгүй.
2	XIII	БС	11	39,959.5	14,085.9	10	37,100.0	28,250.0	
3	XI	ГБХНХС	1	150.0	150.0	1	41,000.0	5,000.0	
4	XV	ЗТС	3	6,609.4	3,054.8	5	146,500.0	23,000.0	
5	XII	ХББОЦС	1	450.0	450.0	5	40,000.0	12,500.0	
6	XVI	ССАЖЗС	4	8,529.0	3,651.6	2	5,200.0	2,000.0	
7	XVIII	ХХААХҮС	2	1,700.0	1,700.0				
8	XX	ЭХС	2	448.0	448.0				
9	XIX	ЭМС				5	15,400.0	6,500.0	
10		БТСҮХ				4	8,000.0	8,000.0	
НИЙТ ДҮН			28	65,307.6	27,321.3	37	308,700.0	92,250.0	

Хүснэгтээс харахад хүргүүлсэн саналаас 12 ТАХ нь улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд аймагт шинээр хэрэгжүүлэхээр сайдуудаас эрх шилжүүлсэн нийт 28 ТАХ-ний 16 нь аймгийн ТЕЗ-аас санал хүргүүлээгүй арга хэмжээнүүд байна.

Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналыг харьяа яамдын Сайдын багцад хуваарилсан ТАХ

Хүснэгт 3. /сая.төгрөг/

№	Хуулийн код	ТЕЗ	Төсвийн хуулиар батлагдсан шинээр хэрэгжих ТАХ-д		
			Тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
1	V	ЗГХЭГ	3	7,361.7	3,681.0
2	XIII	БС	6	28,011.8	9,085.1
3	XVI	ССАЖЗС	2	5,154.9	1,777.5
4	XV	ЗТС	1	2,554.7	1,277.4
Нийт			12	43,083.1	15,821.0

Харьяа яамны Сайдаас эрх шилжүүлсэн ТАХ-ны судалгаа

Хүснэгт 4 /сая.төгрөг/

№	Хуулийн код	ТЕЗ	Төсвийн хуулиар харьяа сайдын багцаас хэрэгжүүлэхээр эрх шилжсэн ТАХ-д		
			Тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
1	V	ЗГХЭГ	1	100.0	100.0
2	XIII	БС	5	11,947.7	5,000.8



3	XV	ЗТС	2	4,054.7	1,777.4
4	XVI	ССАЖЗС	2	3,374.1	1,874.1
5	XVIII	ХХААХҮС	2	1,700.0	1,700.0
6	XX	ЭХС	2	448.0	448.0
7	XI	ГБХНХС	1	150.0	150.0
8	XII	ХББОЦС	1	450.0	450.0
НИЙТ ДҮН			16	22,224.5	11,500.3

Дээрхи ТЕЗ нараас ирүүлсэн ТАХ нь орон нутгаас эдийн засгийн үр өгөөж, нийгмийн ач холбогдол, хэрэгцээ шаардлагын судалгаагүй ТАХ-г Сангийн яаманд хүргүүлсэн байх бөгөөд ямар шаардлага шалгуурыг үндэслэсэн талаар орон нутагт мэдээлэлгүй байна.

А.3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 11 ТАХ-г магадлалаар хянаж төсөвт өртгийг 7,281.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Архангай аймагт шинээр хэрэгжүүлэх 65,307.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27,321.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 28 ТАХ батлагдсаны 21 нь барилга байгууламж, 6 нь тоног төхөөрөмж, нэг нь ТЭЗҮ боловсруулах байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд шинээр хэрэгжих 21 барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл, ажлын даалгаврыг 2021-2024 онд захиалагчаас боловсруулж баталсан байна. Эдгээрээс 11 ТАХ-ний зураг төсвийг Барилгын хөгжлийн төвөөс 2024 онд хянаж төсвийг нь 39,935.7 сая төгрөгөөр баталгаажуулсан, 3 ТАХ нь хянагдаж байна. Барилгын хөгжлийн төвөөс хянаж баталгаажуулсан төсөв нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнийн дүнгээс 7,281.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, 3 ТАХ-ийн төсөв хэдээр нэмэгдэх нь тодорхойгүй байгаа нь ТАХ-ний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, улсын төсөвт хүндрэл үүсгэж болзошгүй байна.

Магадлалын ерөнхий дүгнэлтээр төсөв нэмэгдсэн ТАХ-ний жагсаалт

Хүснэгт 5. /сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Гүйцэтгэгч ийн нэр	Гэрээний үнийн дүн	Магадлалын ерөнхий дүгнэлтийн дугаар	Баталгаа жсан төсөвт өртөг	Гэрээ, магадлал ын дүнгийн зөрүү
		Эхлэх	Дуусах					
1	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Булган сум/	2024	2025	"Цагаан сүмбэр" ХХК	2,430.72	802/2024	3,046.25	615.53
2	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Өндөр-Улаан сум/	2024	2025	"Хөх үзүүр" ХХК	2,453.80	2024.06.06 804/2024	3,347.85	894.05
3	Дотуур байрны барилга, 100 ор /Архангай, Төвшрүүлэх сум/	2024	2025	"ГАЗРЫН ГАГНААС" ХХК	2,810.38	2024.06.25 0962/2024	4,133.48	1,323.10
4	Сургуулийн барилгын өргөтгөл, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар сургууль/	2024	2025	"Гурвантам ир" ХХК	3,484.00	0962/2024	4,133.48	649.48
5	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Хашаат сум/	2024	2026	"Гурвантам ир" ХХК	3,944.00	0963/2024	4,840.47	896.47
6	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 14 дүгээр цэцэрлэг/	2024	2026	"ГАЗРЫН ГАГНААС" ХХК	3,762.60	1323/2024	3,880.89	118.29
7	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар цэцэрлэг/	2024	2026	"ЭСГЭЛ" ХХК	3,162.40	1324/2024	3,233.37	70.97
8	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 9 дүгээр цэцэрлэг/	2024	2026	"Идэр живаа" ХХК	3,953.00	2149/2022	4,246.87	293.87
9	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өгийнуур сум/	2024	2026	"Гурвантам ир" ХХК	3,312.60	0984/2024	4,802.08	1,489.48
10	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өлзийт сум/	2024	2026	"ТАМИР ТАУН" ХХК	3,199.60	1097/2024	4,100.18	900.58



11	Сумын төвийн цахилгаан хангамжийн шинэчлэлт /Архангай, Ихтамир сум/	2024	2024	Эрчим өгий ХХК	141.48	902/2024	170.80	29.32
	Нийт дүн				32,654.6		39,935.71	7,281.13

Харин ЗГХЭГ-ын багцаас шинээр хэрэгжүүлэх Цахир сумын иргэдэд үйлчлэх төвийн барилга барих ажил нь түлхүүр гардуулах нөхцөлтэй бол ЭХС-аас шинээр хэрэгжүүлэх 2 ТАХ нь бага төвөгшилтэй тул магадлалаар баталгаажуулах шаардлагагүй байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 42,293.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 барилга байгууламжид 2009-2024 оны хооронд газар эзэмших зөвшөөрлийг олгожээ. Өөрөөр хэлбэл шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж нь бүгд газрын зөвшөөрөлтэй байна.

Шинээр хэрэгжих барилга байгууламжид олгосон газрын зөвшөөрөл

Хүснэгт 6. /Сая. Төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг (сая төг)	Газрын зөвшөөрөл олгосон		
			Шийдвэр	Дугаар	Огноо
V.1.12	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Булган сум/	2,453.9	06507-A/09/2024	170001045	2024/02/15
XIII.1.1.261	Дотуур байрны барилга, 100 ор /Архангай, Төвшрүүлэх сум/	3,085.7	06528-115/2009	000001222	2009/10/22
XIII.1.1.314	Сургуулийн барилгын өргөтгөл, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар сургууль/	3,607.1	06501-A/613/2018	0000085731	2018/12/06
XIII.1.1.340	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 5 дугаар цэцэрлэг/	8,830.0	06501-A/592024	0000258975	2024/02/07
XIII.1.1.351	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Хашаат сум/	4,246.9	06537-52/2011	0000102506	2011/06/29
XIII.1.1.352	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 14 дүгээр цэцэрлэг/	4,246.9	06501-A/58/2024	0000086651	2024/02/08
XIII.1.1.353	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар цэцэрлэг/	3,473.9	06501-A/59/2024	0000258974	2024/02/07
XIII.1.1.355	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 9 дүгээр цэцэрлэг/	4,246.9	06501-A/544/2018	000443890	2018/10/18
XIII.1.1.356	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өгийнуур сум/	3,473.8	06516-/8/2024	0000253977	2024/01/25
XIII.1.1.357	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өлзийт сум/	3,473.8	06519-A/39/2024	0000095075	2024/05/02
XVI.3.1.27	Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/	1,154.9	2024-03-18-ний А/148	0000313185	2024/03/18
Нийт		42,293.8			

Аймгийн Засаг даргад 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн 6,400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 7 техник, тоног төхөөрөмж, ТЭЗҮ-ийн ажлуудад захиалагчаас ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж баталсан нь төсөвлөлтийн шаардлагыг хангасан байна.

2024 онд шинээр хэрэгжих тоног төхөөрөмж, ТЭЗҮ-ийн судалгаа

Хүснэгт 7. /сая.төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	Техникийн тодорхойлолт ажлын даалгавартай эсэх
V.1.15	Аймаг сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж Архангай	100.0	100.0	тийм
XIII.1.3.10	Боловсролын байгууллагуудын тоног төхөөрөмж /Архангай/	1,000.0	1,000.0	тийм
XIV.5.3.6	Ахмадын хөгжлийн өргөөний тоног төхөөрөмж /Архангай, Эрдэнэбулган сум/	150.0	150.0	тийм
XVI.2.3.3	Аймгийн хөгжимт драмын театрын тоног төхөөрөмж /Архангай, Эрдэнэбулган сум/	3,000.0	1,500.0	тийм
XVIII.3.19	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Архангай/	1,000.0	1,000.0	тийм



XVIII.3.37	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих "Бяслаг" төсөл /Архангай, Тариат сум/	700.0	700.0	тийм
XV.1.4.3	Сумын төвийн их тойруу хатуу хучилттай авто замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Архангай, Эрдэнэбулган сум/	450.0	450.0	тийм
Нийт		6,400.0	4,900.0	

А.4 Шинээр хэрэгжих ТАХ нь төрийн хэмнэлтийн хуульд нийцсэн, тухайн шатны хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 65,307.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ТАХ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1⁴, 13.3⁵, 13.4⁶ дэх заалттай нийцсэн бөгөөд тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөжээ.

БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН БАЙНА.

Б.1. Аймгийн хэмжээнд улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих ТАХ-ний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92.8 хувьтай байна.

МУЗГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны 409 дугаар тушаалаар 8 ТЕЗ-ын багцаас Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 65,307.6 сая төгрөгийн өртөг бүхий 28 төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6⁷-д заалтын хүрээнд аймгийн ХААГ-аас баталсан 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу tender.gov.mn цахим хуудсаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. /Тайлангийн хавсралт 2-т худалдан авах ажиллагааны дэлгэрэнгүй судалгааг оруулав/

Аймгийн хэмжээнд 2024 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа

№	Хуулийн дугаар	ТЕЗ	Анх батлагдсан		Тодотгол		Гэрээний үнийн дүн	Тендерийн хэмнэлт
			Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг		
Төсвийн хуулиар батлагдсан ТАХ								
1	V	ЗГХЭГ	4	7,461.7	4	7,461.7	4,981.2	26.6
2	XIII	БС	11	39,959.5	11	39,959.5	37,182.8	2,776.7
3	XI	ГБХНХС	1	150.0	1	150.0	126.5	23.5
4	XV	ЗТС	3	6,609.4	3	6,609.4	6,594.5	14.9
5	XII	ХББОЦС	1	450.0	1	450.0	428.7	21.3
6	XVI	ССАЖЗС	4	8,529.0	4	8,529.0	7,849.0	305.9
7	XVIII	ХХААХҮС	2	1,700.0	2	1,700.0	1,684.5	15.5
8	XX	ЭХС	2	448.0	2	448.0	410.3	37.7
НИЙТ ДҮН			28	65,307.6	28	65,307.6	59,257.5	3,222.1

⁴ 13.1-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална"

⁵ 13.3-д "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно"

⁶ 13.4-д "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно"

⁷ 45.6-д "Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 45.5-д заасан захиалагч өөрийн хэрэгцээнд худалдан авахаас бусад тохиолдолд тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж зохион байгуулна"



Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 92.8 хувь буюу 26 ТАХ-ний гүйцэтгэгчтэй 59,257.5 сая төгрөгийн гэрээ байгуулах эрх олгож 3,222.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг бий болгожээ.

Харин 2,453.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Цахир сум/”, 374.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аялал жуулчлал, соёлын өв /Архангай, Цахир сум” 2 ТАХ-ний тендер, худалдан авах ажиллагааг цахимаар 4-6 удаа зохион байгуулсан боловч гүйцэтгэгч оролцоогүй шалтгаанаар амжилтгүй болсон байна.

Дүрслэл 2. Нээлттэй тендер шалгаруулалт



Нийт 28 ТАХ-ний 89.3 хувь буюу 64,922.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 ТАХ-ний худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж 23 ТАХ-ний гүйцэтгэгчтэй 58,879.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулж, 3,215.0 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг бий болгосон байна.

Дүрслэл 3. Харьцуулалтын арга

Харьцуулалтын аргаар 10.7 хувь буюу 385.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулж 3 гүйцэтгэгчтэй 378.5 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулж, 7.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг бий болгожээ.



Б.2 Шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний 96.2 хувийн тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, баталсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1⁸, 11.2⁹-т заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч шинээр хэрэгжүүлэх 65,307.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ТАХ тус бүрд үнэлгээний хороог байгуулж, СС-ын 2023 оны 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалаар баталсан “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу ТШӨХ, тендерийн баримт бичгийг боловсруулжээ. /Тайлангийн хавсралт 2-т худалдан авах ажиллагааны дэлгэрэнгүй судалгааг оруулав/

Аудитаар шинээр хэрэгжсэн 27 ТАХ-ний тендерийн баримт бичиг боловсруулалт, иж бүрдэл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт зэргийг тулган шалгахад тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, үе шатны ажлын хуваарь, цахим урилга зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулж аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргаар баталгаажуулсан байна.

Харин ХХААХҮС-аас 2024 онд эрх шилжүүлсэн 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих “Бяслаг” тоног төхөөрөмж ангиллаар батлагдсан төсөл, арга хэмжээг сэндвичин барилга барихаар өөрчилж, ажлын даалгаврыг баталж, барилгын ажлын тендерийн баримт бичиг боловсруулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

⁸ 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална”

⁹ 11.2-д “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана”



Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.38.¹⁰, 4.8.38.2¹¹ заасныг зөрчсөн байна.



Иймд хуулиар баталсан төсөл арга хэмжээний эдийн засгийн ангиллыг өөрчилж, ажлыг даалгавар боловсруулсан, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг Аймгийн засаг даргад хүргүүлэв.

Б.3 Тендерийн баримт бичигт тусгасан шаардлага хангаагүй этгээдээр 303.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламжийн ажлыг гүйцэтгүүлэхээр шалгаруулсан байна.

Архангай аймгийн хэмжээнд улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжсэн 65,307.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулсан ба тайлант онд 2 ТАХ-ний тендер худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч оролцоогүй гэсэн шалтгаанаар хэрэгжээгүй.

Харин 26 ТАХ-ний тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй 59,257.5 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулсан байна.

Аудитаар тендерт шалгарсан 26 гүйцэтгэгчийн тендерийн баримт материалыг ТШӨХ, тендерийн баримт бичигт тавигдсан шаардлагын дагуу тулган шалгахад дараах зөрчил илэрсэн.

- ✓ ЭХС-аас шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн 303.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хашаат, Цэцэрлэг сумын эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж” -ийн тендерийн баримт бичигт заасан ижил төстэй ажил үйлчилгээний хувьд эрчим хүчний угсралтын ажлын туршлагыг хангасан нотлох баримтыг бүрэн ирүүлээгүй “Цацрах хангай ХХК”-ийг шалгаруулсан нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17.2¹², 17.2.1¹³, 17.2.2¹⁴ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.



Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн ХААГ-т хүргүүлэв.

Тайлант онд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэртэй холбоотой 2 тендерт оролцогчоос Сангийн яаманд гомдол гаргаж тендер худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг шалгуулсан байна. Үүнд:

- ✓ Боловсролын Сайдаас эрх шилсэн XIII.1.1.340 хуулийн дугаартай 8,830.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 3 дугаар багт баригдах “240 хүүхдийн ортой 5 дугаар цэцэрлэгийн барилга” угсралт”-ын тендерт оролцогч нар нь үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй хэмээн гомдол

¹⁰ 8.38.-д Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний ангиллын төслийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр байршлыг солих хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх

¹¹ Хуулиар батлагдсан төсөл арга хэмжээний төсөвт өртөг, нэр байршил хүчин чадалд өөрчлөлт оруулахгүй зөвхөн тухайн жилд санхүүжих дүнд зохицуулалт хийх,

¹² 17.2-т “Техникийн чадавх, туршлагын талаарх мэдээллийг дараах баримт бичгээр нотолж болно”

¹³ 17.2.1-т “ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт”

¹⁴ 17.2.2-д “бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт”



- гаргасныг СЯ-аас хянаад үнэлгээний хорооны тендерээс татгалзсан 2 шалтгааныг үндэслэлтэй байна гэж шийдвэрлэсэн.
- ✓ ГБХНХС-с эрх шилжсэн XIV.5.3.6 хуулийн дугаартай 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Архангай аймгийн ахмадын хороонд нийлүүлэх тоног төхөөрөмж”-ийн тендерт оролцогчоос үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй хэмээн гомдол гаргасныг СЯ-аас хянаад үнэлгээний хорооны тендерээс татгалзсан шалтгааныг үндэслэлтэй байна шийдвэрлэжээ.

БҮЛЭГ В. УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТУХАЙН ОНД ХЭРЭГЖҮҮЛЖ ДУУСАХААР ТӨЛӨВЛӨСӨН 17 ТАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТ 76.5 ХУВЬТАЙ БАЙНА

В.1. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг бүрэн хянаагүйн улмаас бодит гүйцэтгэлээс 829.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оноос үргэлжлүүлэх болон шинээр хэрэгжүүлэх 39 ТАХ-нд 2024 онд 76,120.0 сая төгрөг санхүүжилт олгохоор батлагдсанаас аймгийн төрийн сангийн дансаар 37 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилт 56,277.4 сая төгрөгийн шилжүүлэг хийгдсэн байна. Үүнээс гүйцэтгэгч нарт 50,547.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 5,729.9 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ. Олгохоор төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл 66.4 хувьтай байна.

ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилсан судалгаа

ТЕЗ	Эрх шилжүүлсэн		Санхүүжилт хийгдсэн		Зөрүү	
	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн
ЗТХСайд	6	38,095.8	6	31,932.5	-	6,163.3
Боловсролын Сайд	15	18,610.2	15	13,357.0	-	5,253.2
ХХААХҮС	2	1,700.0	1	835.8	1	864.2
ГБХНХС	1	150.0	1	126.5	-	23.5
ХББОСС	2	5,950.0	2	838.9	-	5,111.1
ЭХСайд	2	448.0	2	393.5	-	54.5
ССАЖЗС	6	7,182.8	5	1,575.9	1	5,606.8
ЗГХЭГ	5	3,983.2	5	1,487.4	-	2,495.8
Нийт	39	76,120.0	37	50,547.5	2	25,572.5

Хүснэгтээс харахад дараах 2 төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгогдоогүй байх бөгөөд шалтгааныг тодруулан авч үзвэл:

барилгын фото зураг 2025.03.28-ны байдлаар

1. ХХААХҮС-аас 2024 онд эрх шилжүүлсэн 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих “Бяслаг” төслийн гүйцэтгэгч “Маргад оюу бюлдинг” ХХК-тай 2024 оны 08 дугаар сарын 26-наас 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл хугацаанд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба барилгын ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Уг төсөл, арга хэмжээний ангиллыг “тоног төхөөрөмж” гэж Төсвийн тухай хуулиар баталсан байхад ангиллыг өөрчилж барилгын ажил гүйцэтгүүлснээс 698.8 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна. Эдийн засгийн ангилал өөрчилж тендер зохион





байгуулсан зөрчлийн талаар энэ тайлангийн Б.2-д дэлгэрэнгүй тусгасан болно. Тухайн ТАХ-ийг гүйцэтгэгч компани гэрээний дагуу хэрэгжүүлсэн байх тул ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгох, барилгыг үр ашигтай зориулалтын дагуу ашиглах асуудлыг холбогдох байгууллагуудад танилцуулж шийдвэрлүүлэх саналыг хүргүүлж байна.

барилгын фото зураг 2025.03.28-ны байдлаар

2. ССАЖЗС-аас 2022 онд эрх шилжүүлсэн 4,075.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилга”-ын ажлын гүйцэтгэгч “Энигма констракшн” ХХК-тай 2022.04.14-2023.10.31-ыг хүртэл хугацаанд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. 2024 онд захиалагчаас гэрээг сунгаагүй ба 3,325.3 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.



Тайлант онд аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн данснаас өмнөх оноос шилжин хэрэгжих 4 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд үндэслэн 1,841.9 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгожээ.

Харин Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 249 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/920 дугаар захирамжаар 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан байнгын ашиглалтад хүлээн авсан 5 барилга байгууламжийн чанар баталгаа болох 1,025.4 сая, гэрээний хугацаагаар дараа он руу шилжсэн 15 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох 4,704.5 сая нийт **5,729.9** сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ. /Тайлангийн хавсралт 3-т барьцаа ТАХ-ний үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн судалгааг оруулав/

Дүрслэл 4. Нийт олгосон санхүүжилтийн хуваарилалт

Тайлант онд улсын төсвөөс аймагт олгосон нийт **56,277.4** сая төгрөгийн санхүүжилтийн 86.9 хувь буюу 48,949.3 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 2.0 хувь буюу 1,137.7 сая төгрөгийг зураг төсөв, зохиогчийн хяналтын зардалд, 0.8 хувь буюу 460.5 сая төгрөгийг захиалагчийн хяналтын зардалд, 10.2 хувь буюу 5,729.9 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. /Хэрэгжсэн ТАХ-ний жагсаалтыг тайлангийн хавсралт №3-тай дэлгэрэнгүй танилцана уу/



Боловсролын Сайдаас 2022 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 4,137.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 160 хүүхдийн суудалтай бага сургуулийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар баг/-ын гүйцэтгэгч “Ди Ти Эм строй” ХХК-д 2024 оны байдлаар бодит гүйцэтгэл 35 хувьтай байхад 61.5 хувь гэж нийт бодит гүйцэтгэлээс 829.0 сая төгрөг илүү буюу нийт 2,544.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Энэ асуудлыг шалгуулахаар аймгийн ГХБХБГ-ын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 876 дугаар албан бичгээр аймгийн Цагдаагийн газарт хүргүүлж мөрдөн шалгах ажиллагаа хийгдэж байна гэсэн тайлбарыг ирүүлээд байна.



Гүйцэтгэгч “Ди Ти Эм строй” ХХК-аар олгосон санхүүжилтэд тохирох буюу гүйцэтгээгүй байгаа 829.0 сая төгрөгийн ажлыг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор гүйцэтгүүлж, гэрээг дүгнэн холбогдох арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

В.2 Аймгийн хэмжээнд 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн ТАХ-ний 23.5 хувийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, гэрээ дүгнээгүй байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 196,606.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 37 ТАХ-ний 70.3 хувь нь барилга байгууламж, 13.5 хувь нь тоног төхөөрөмж, 5.4 хувь нь их засвар, ТЭЗҮ эзэлж байна.

Тайлант онд эрх шилжин хэрэгжсэн 37 ТАХ-ээс гэрээний хугацаагаар он дамжин хэрэгжих 20 ТАХ, тухайн онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 17 ТАХ байна.

Үүнээс 13 ТАХ-ийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж ашиглалтад оруулсан бол үлдэх 4 ТАХ нь гүйцэтгэгчийн буруугаас гэрээний хугацаанд хэрэгжээгүй байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний ангилал, гэрээний хугацаанд хэрэгжээгүй ТАХ-ний тоо, гэрээний дүн

Хүснэгт 10 /сая.төгрөг/

Харьяа Сайд	Хэрэгжсэн ТАХ		Барилга байгууламж		Тоног төхөөрөмж		Их засвар		ТЭЗҮ		Гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй	
	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	ТАХ-ний тоо
ЗТХСайд	108,540.9	5	108,540.9	5								
Боловсролын Сайд	45,820.4	15	44,934.3	13	886.1	1					4,137.7	1
ХХААХҮС	985.8	2			985.8	1					698.8	1
ГБХНХС	126.5	1			126.5	1						
ХББОСС	27,393.6	2	26,964.8	1					428.8	1		
ЭХСайд	410.9	2	410.9	2								
ССАЖЗС	7,849.0	5	4,975.4	2	2,873.6	1					5,216.2	2
ЗГХЭГ	5,479.5	5	4,884.5	3	96.8	1	498.2	1				
Нийт дүн	196,606.5	37	190,710.8	26	4,968.8	5	498.2	1	428.8	1.00	10,052.7	4

Гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалан төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй удааширч байгаа нь өртөг нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Тухайлбал:

- ✓ Боловсролын Сайдаас 2022 онд эрх шилжүүлсэн 4,137.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн 160 хүүхдийн суудалтай бага сургуулийн барилга”-ын ажлын гүйцэтгэгч “Ди ти и Эм строй” ХХК нь 2024.08.25-ыг хүртэл хугацаанд гүйцэтгэж хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй.
- ✓ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын Сайдаас 2022 онд эрх шилжүүлсэн 4,075.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төв монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилга”-ын ажлын гүйцэтгэгч “Энигма Констракшн” ХХК нь 2023.10.31-ыг хүртэл хугацаанд гүйцэтгэж хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, 2024 онд гэрээ сунгалт хийгдээгүй, санхүүжилт олгоогүй байна.
- ✓ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын Сайдаас 2019 онд эрх шилжүүлсэн 1,140.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хотонт сумын Солийн Данзаны нэрэмжит музей, цэцэрлэгт хүрээлэн”-гийн барилгын ажлын гүйцэтгэгч “Жоншт” ХХК нь



2024.09.18-ыг хүртэл хугацаанд гүйцэтгэж хүлээлгэн өгөхөөр гэрээ сунгалт хийгдсэн боловч гэрээний хугацаанд гүйцэтгээгүй.

- ✓ Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдаас 2024 онд эрх шилжүүлсэн 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих “Бяслаг” төслийг 2024.12.17-ыг хүртэл хугацаанд гүйцэтгэж хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаанд гүйцэтгээгүй.



Гэрээт хугацаанд ажлаа хэрэгжүүлээгүй дээрх гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээг дүгнэж, гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлага тооцох арга хэмжээг авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжүүлсэн боловч гэрээний хугацаанд ашиглалтад оруулаагүй, гүйцэтгэл удааширч, төсөвт өртөг нэмэгдсэн барилгуудад хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулах саналыг ЯАГ-т хүргүүлснээс дараах барилгуудад шинжээч томилогдон ажиллаж байна. /Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү/ Үүнд:

1. Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /XVII.1.28/ ажлыг 2022 оноос Энигма констракш ХХК нь 26,968.8 сая төгрөгөөр түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулсан нийт ажлын гүйцэтгэл 24.7 хувьтай. Ажлын гүйцэтгэл удаашралтай. ТЭЗҮ, зураг төсвийн дагуу үндсэн ажлууд хийгдээгүй.
2. Сургуулийн барилга, 320 суудал Архангай, Цахир сум /XIII.1.1.25/ Лорд скай ХХК нь 2019 оноос хойш гүйцэтгэсэн 6 жил гүйцэтгэсэн, төсөвт өртөг 7,082.6 сая төгрөг болж нэмэгдсэн.
3. Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор Архангай, Тариат сум /XIII.1.1.54/ Хорго групп ХХК нь 2019 оноос хойш 6 жил гүйцэтгэсэн, төсөвт өртөг 1065.0 сая төгрөг болж нэмэгдсэн.

Үүнээс гадна аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор Архангай Эрдэнэбулган сум, Соёлын төвийн барилга Архангай Өгийнуур сум, Спорт ордны барилга, Архангай Эрдэнэбулган сум эдгээр барилгуудын төсөвт өртгийг магадлалаар хянаж нэмэгдүүлсэн үндэслэлийг шалгах бие даасан аудитад хамруулж байна.

В.3. Тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн ТАХ-ний 15.4 хувь буюу 2 барилга байгууламжийг ТЭЗҮ, зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байна.

Аймгийн ГХБХБГ-ын Барилга хот байгуулалтын хэлтсээс 24 барилга байгууламжид тухай бүр захиалагчийн хяналт хийж, захиалагчийн хяналтын явцын дүгнэлт гарган баталгаажуулж ажилласан байна. ЗТХС-аас эрх шилжсэн 6 зам, гүүрний байгууламжийн ажилд зөвлөхийн гэрээгээр “Мөнхөд ашдын зам ХХК”, “Ар Си Эс Си” ХХК, “Эн би си си ХХК”, “Арвай нутгийн зам” ХХК, “Жи Ар Си” ХХК-иуд зөвлөх үйлчилгээг гүйцэтгэж, зөвлөх үйлчилгээний тайлан, дүгнэлт, ил далд ажлын акт үйлдэж баталгаажуулан фото зургаар баримтжуулсан байна. Гүйцэтгэгчдээс өгсөн үүрэг даалгаврыг ил далд ажлын акт үйлдэн захиалагч, зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч нараар баталгаажуулан ажлын гүйцэтгэлд хавсаргажээ.



Тайлант онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 17 ТАХ-нээс 2 ТАХ нь улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаагүй, ТЭЗҮ, зураг төсөвт тусгасан ажлыг хэрэгжүүлээгүй, ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг засварлах арга хэмжээ аваагүй байна.

Гэрээний хугацаанд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан эрх шилжсэн 15, эрх шилжээгүй 2 нийт 17 барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлд захиалагч, ГНАГ-2025/06-01-ШТА-НА

зохиогч, улсын комиссын хяналтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг газар дээр нь очиж ТЭЗҮ, зураг төсвийн дагуу тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Боловсролын Сайдын багцаас эрх шилжээгүй 2021.10.21-2024.12.31-ны өдрийг хүртэл хугацаанд хэрэгжсэн 6,066.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй "Батцэнгэл сумын 320 хүүхдийн барилга"-ын ажлыг 2024.11.28-ны өдөр улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн ба ашиглалтын явцад 1 болон 3 давхрын 4-н өрөөний дүүргэлтийн хана цууралт үүссэн, спорт заалны агааржуулалтыг холбоогүй, 4 ширхэг паар ажиллахгүй, 1, 2, 3 давхрын ариун цэврийн өрөөний агааржуулалтыг гэрлийн унтраалгаас салгаагүй, ус цэвэршүүлэгч төхөөрөмжийг суулгаагүй байна.



- ✓ Боловсролын Сайдын багцаас 2022 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 3,834.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Эрдэнэбулган сумын "160 хүүхдийн суудалтай 4 дүгээр сургуулийн барилга, спорт заал"-ны ажлын гүйцэтгэгч Эйч ар ви констракшн ХХК нь 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн ба улсын комиссоос өгсөн 11 ажлаас 7 ажлыг хэрэгжүүлээгүй мөн төсөвт тусгасан 4.9 сая төгрөгийн гадна талын сагсны талбайн хавтан, сагсны шит суурилуулах ажлыг хийгээгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 14.6, 14.7 дахь хэсэг, МУЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.9.2-д "... барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлуулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна ...", МУЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 8.1¹⁵, 8.2.1¹⁶ дэх заалттай нийцэхгүй байна.



Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын болон ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг гүйцэтгэгч байгууллагаар засварлуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

В.4. Тайлант онд байнгын ашиглалтад хүлээн авсан ТАХ-г зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа боловч 20,923.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна.

¹⁵ 8.1-д "Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ"

¹⁶ 8.2.1-д "барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт"

ГНАГ-2025/06-01-ШТА-НА



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд эрх шилжин хэрэгжсэн 12,870.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 12, эрх шилжээгүй 12,038.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 7 нийт 19 ТАХ-г улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Тайлант онд ашиглалтад хүлээн авсан нийт ТАХ-ний 87.2 хувийг 21,714.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 11 барилга байгууламж, 2 хувийг 498.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй их засвар, 1.7 хувийг 428.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй ТЭЗҮ, 9.1 хувийг 2,267.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй мал амьтад, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээ эзэлж байна.

Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй ТАХ, гэрээний үнийн дүнгийн судалгаа

Хүснэгт 11 /сая.төгрөг/						
№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний дүн	Хүлээн авсан актын огноо	Тусгаадагүй, шалтгаан тайлбар
1	XIII.1.1.113	Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Батцэнгэл сум/	"Тамирын цахиур" ХХК	6,066.4	2024.11.28	ТӨБЗГ-ын тогтоолгүй
2	XIII.1.1.134	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Төвшрүүлэх сум/	"ЭСГЭЛ" ХХК	2,480.0	2024.05.19	ТӨБЗГ-ын тогтоолгүй
3	XIII.1.1.25	Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Цахир сум/	"ЛОРД СКАЙ" ХХК	7,082.6	2025.02	ТӨБЗГ-ын тогтоолгүй
4	XIII.1.1.54	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор /Архангай, Тариат сум/	"ХОРГО ГРУПП" ХХК	1,065.0	2025.03	ТӨБЗГ-ын тогтоолгүй
5	XV.2.1.1	Хануй голын төмөр бетон гүүр /Архангай, Хайрхан сум/	"Эвт-Уул" ХХК	3,320.0	2023.11	ТӨБЗГ-ын тогтоолгүй
6	XX.1.39	Сумын төвийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэлт /Архангай, Ихтамир сум/	"Эрчим өгий" ХХК	141.5	2024.11.16	ТӨБЗГ-ын тогтоолгүй
7	XX.1.39	Сумын төвийн цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Архангай, Цэцэрлэг, Хашаат сумд/	"Цацрах Хангай" ХХК	269.4	2024.10.15	ТӨБЗГ-ын тогтоолгүй
8	V.2.1	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Архангай, Ихтамир сум/	ЭНХТӨГС ТЭМҮҮЛЭЛ	498.3	2024.06.20	Бүртгэлд тусгаагүй
Нийт дүн				20,923.2		

Хүснэгтээс харахад байнгын ашиглалтад хүлээн авсан 20,923.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 ТАХ-г ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2¹⁷, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.1¹⁸, 4.1.4¹⁹, 4.4²⁰ дэх заалттай нийцэхгүй байна. /Тайлангийн хавсралт №4 –с дэлгэрэнгүй танилцана уу/



Улсын комиссын актаар хүлээн авсан барилга байгууламжийн 7 ТАХ-г ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

¹⁷ "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"
¹⁸ Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах шаардлагагүй
¹⁹ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ
²⁰ Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана
ГНАГ-2025/06-01-ШТА-НА



Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт 84 хувьтай байна.

Өмнөх аудитаар Аймгийн Засаг дарга, ГХБХБГ, ОНӨГ-уудад нийт 2 заалт бүхий зөвлөмж, 6 албан шаардлага, 1 төлбөрийн актыг хүргүүлж, биелэлтийг албан бичгээр тооцож ирүүлсэнд тулган шалгахад барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй 2 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авч өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 12. Өмнөх аудитаар шалгагдагч байгууллагад хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт /хувиар/

Шалгагдагч байгууллага	Шалгагдагч байгууллагад хүргүүлсэн		Бүрэн хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Хэрэгжээгүй		Дундаж биелэлт хувиар
	Шийдвэрийн тоо	Мөнгөн дүн	Шийдвэрийн тоо	Мөнгөн дүн	Шийдвэрийн тоо	Мөнгөн дүн	Шийдвэрийн тоо	Мөнгөн дүн	
Аймгийн Засаг даргад	4	2,024.8	2	1,499.8	1	525.0	1		68.7
Аймгийн ГХБХБГ-т	2	1,096.1	2	1,096.1					100.0
Аймгийн ОНӨГ-т	3	55,007.2	2	156.7	1	54,850.5			83.3
дүн									84.0

Аймгийн ОНӨГ-аас албан шаардлагын мөрөөр 6 яаманд ТӨБЗГ-аас зөвшөөрөл гаргуулан барилга байгууламжийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгах хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн боловч 2025 оны 04 дүгээр сарын байдлаар зөвшөөрөл олгогдоогүй шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 11 ТАХ-ийг баталсныг магадлалаар хянаж төсөвт өртгийг 7,281.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
- ✓ Аймгийн хэмжээнд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 10.7 хувь нь аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.
- ✓ Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих ТАХ-ний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92.8 хувьтай байна.
- ✓ Батлагдсан төсөл арга хэмжээний ангиллыг өөрчилж тендерийн баримт бичгийг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж хууль зөрчсөн байна.
- ✓ Тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангаагүй этгээдээр 303.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламжийн ажлыг гүйцэтгүүлэхээр шалгаруулсан байна.
- ✓ Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хянаагүйн улмаас бодит гүйцэтгэлээс 829.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.
- ✓ Аймгийн хэмжээнд 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн ТАХ-ний 23.5 хувийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, гэрээ дүгнээгүй байна.
- ✓ Тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн ТАХ-ний 15.4 хувь буюу 2 барилга байгууламжийг ТЭЗҮ, зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байна.
- ✓ Тайлант онд байнгын ашиглалтад хүлээн авсан ТАХ-г зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа боловч 20,923.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.
- ✓ Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн 84 хувийг хэрэгжүүлсэн байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 82 ХУВЬТАЙ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт **26,589.1 сая төгрөгийн** зөрчил илэрснээс 5,465.4 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 698.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 20,424.9 сая төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

-----oOo-----



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Ганхуягт

1. Тайлант онд улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн хугацаанд хэрэгжиж ашиглалтад хүлээн авсан 20,424.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 7 барилга байгууламжийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 05 дугаарын 21-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2025.04.21 № 01/558
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагын 259 дүгээр албан бичгээр ирүүлсэн Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн асуудлын бүртгэл, тайлантай танилцлаа.

1. Асуудлын бүртгэлийн 2,3 дахь хэсэгт заасан зөрчлүүдэд хавсралтаар тайлбар хүргүүлж байна.

2. Асуудлын бүртгэлийн 4 дэх хэсэгт заасан “Орон нутгийн үйлдвэрлэлийн дэмжих Бяслэг төсөлтэй холбоотой асуудлыг хариуцлага тооцох болгож, гүйцэтгэгч компанийг хийсэн ажлын гүйцэтгэлээр хохиролгүй болгох талаар холбогдох газарт уламжилж, тайланд дурдаж, дээрх зөрчлүүдийг асуудлын бүртгэлээс хасч, өөрчилж өгнө үү.

*Анхны
Салсан
Сүхбаатар
Уянга*



Б.ЦЭРЭННАДМИД

65250050024

дэмжих Бяслэг төсөл” арга хэмжээний эдийн засгийн ангиллыг өөрчилж ажлын даалгаврыг боловсруулсан, худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулах эрх олгосон буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлж, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нь гэрээний дагуу хэрэгжүүлсэн байх тул ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгох, тухайн барилгыг зориулалтын дагуу үр ашигтай ашиглах талаар холбогдох байгууллагуудад танилцуулж шийдвэрлүүлэх арга хэмжээг авах саналыг хүргүүлээ” гэж аудитын тайланд өөрчлөн тусгалаа.

Санал тайлбарыг шийдвэрлэсэн тухай:

1. Тайлангийн төсөлд санал ирүүлсэн албан бичгийн 1 дэх хэсэгт дурдсан тайлбар, нотлох баримтыг судлаад дараах байдлаар шийдвэрлэлээ. Үүнд:

- Ижил төстэй ажлын туршлага хангасныг нотлох баримтыг бүрэн ирүүлээгүй “Цацрах хангай” ХХК-ийг сонгон шалгаруулсан зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг ХААГ-т хүргүүлэх

- Эрдэнэбулган сумын 6-р багийн 160 хүүхдийн суудалтай хичээлийн байрны барилгын ажлын гүйцэтгэгч нь хуурамч баримт бүрдүүлж бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт авсан асуудлыг Цагдаагийн газраар шалгуулж байгаа тул илүү авсан санхүүжилтэд нийцсэн ажлыг хянаж бүрэн гүйцэтгүүлэх, гэрээг дүгнэж холбогдох арга хэмжээг авах хугацаатай албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэх болсон талаар тайланд тусгалаа.

2. Албан бичгийн 2 дахь хэсэгт тусгаж ирүүлсэн саналын тухайд “Орон нутгийн үйлдвэрлэлийг



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1440

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргад (Б.Цэрэннадмид), Орон нутгийн өмчийн газрын дарга (Х.Ганхуяг)-т зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

5.Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА





Тэргүүлэх аудиторын 2024 оны 04 дүгээр сарын 21 өдрийн
А/19 тоот тушаалын хавсралт №1

"Улс төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитын код: АРА-2024/16-01-ШТА-НА

№	Хүргүүлсэн шийдвэрийн				Хэрэгжилтийг хариуцах		
	Утга	Мөнгөн дүн	Тоо	Шийдвэр	Шийдвэрийн огноо дугаар	Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	Боловсролын Сайдаас 2022 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 4,137.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 160 хүүхдийн суудалтай бага сургуулийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар баг-ын гүйцэтгэгч "Ди Ти Эм строй" ХХК-д 2024 оны байдлаар бодит гүйцэтгэл 35 хувьтай байхад 61.5 хувь гэж нийт бодит гүйцэтгэлээс 829.0 сая төгрөг илүү буюу нийт 2,544.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	829.00	1	Албан шаардлага	2025.04.21 362	Аймгийн ГХБХБГ-ын дарга	Ч.Отгонжаргал
2	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжсэн 28 төсөл арга хэмжээний төндөрийн баримт бичгийг тулган шалгахад 2024 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр төндөр зарлагдсан ЭХЯ/20240101048 дугаартай Хашаат, Цэцэрлэг сумын эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамжийн төндөрт нийт 5 компани төндөрийн баримт материал ирүүлж үнэлгээний хороо 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хуралдаж Цацрах хангай ХХК-г шалгаруулсан байна. Гэвч ТББ-д бичигт заасан ижил төстэй ажил үйлчилгээний хувьд эрчим хүчний угсралтын ажлын туршлага байхгүй, хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл шаардлага хангаагүй, цахим системд дэлгэрэнгүй мэдээллийг илгээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчлэгээ худалдан авах тухай хуулийн 17.2, 17.2.1, 17.2.2 21.1.1 дэхь заалтуудыг тус тус зөрчсөн байна.	303.70	1	Албан шаардлага	2025.04.21 363	ХААГ	Э.Гончигдамбаа
3	Боловсролын Сайдаас 2022 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 3,834.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй "Сургуулийн барилга, спорт заал, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 4 дүгээр сургууль"-ын ажлын гүйцэтгэгч Эйч ар ви констракшн ХХК нь 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссоос өгсөн 11 ажлаас 7 ажлыг хэрэгжүүлээгүй мөн төсөвт тусгасан гадна талын сагсны талбайн хавтан, сагсны шит суурилуулах ажлыг хийгээгүй байна. Боловсролын Сайдын багцаас эрх шилжээгүй "Батцэнгэл сумын 320 хүүхдийн барилга"-ын ажлыг 2024.11.28-ны өдөр улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн ба ашиглалтын явцад 1 болон 3 давхрын 4-н өрөөний дүүргэлтийн хана цууралт үүссэн, спорт заалны агааржуулалтыг холбоогүй, 4 ширхэг паар ажиллахгүй, 1, 2, 3 давхрын ариун цэврийн өрөөний агааржуулалтыг гэрлийн унтраалгаас салгаагүй, ус цэвэршүүлэгч төхөөрөмжийг суулгаагүй байна. Барилгын тухай хуулийн 14.6, 14.7 дахь хэсэг, МУЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.9.2-д "... барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, ул маргах журмаар засваруулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна ..." гэж заасныг зөрчсөн байна.	3,834.40	1	Албан шаардлага	2025.04.21 365	Аймгийн ГХБХБГ-ын дарга	Ч.Отгонжаргал
4	МУЗГ-ын Хэрэг эрхлэх газраас 2021 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 498.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй "Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Архангай, Ихтамир сум"-ын их засварын ажлыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан хэдий ч бүртгэл тайланд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.1, 4.1.4, 4.4 дэх заалттай нийцэхгүй байна. /бүртгэлд тусгаагүй ТАХ-ний жагсаалтыг хавсаргав/	498.30	1	Албан шаардлага	2025.04.21 366	Ихтамир ЗДТГазар	Д.Нямжаргал
5	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан 20,424.9 сая төгрөгийн гэрээний үнэтэй 7 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.1, 4.1.4, 4.4 дэх заалттай нийцэхгүй байна. /бүртгэлд тусгаагүй ТАХ-ний жагсаалтыг хавсаргав/	20,424.90	1	Зөвлөмж	2025.04.21 84	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
6	Захиалагчтай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болсон 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж хариуцлага тооцох арга хэмжээ аваагүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар 46.1.6 "Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавих...", МУЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилга захиалагчийн дүрэм"-ийн 3.6-д "Захиалагч ... гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, ... гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана", гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний өрөнхий нөхцөлийн 46.1-д "Гүйцэтгэгч ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хонго тутам гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө" гэж заасантай нийцэхгүй байна. /Гэрээнд хугацаанд хэрэгжээгүй барилга байгууламжийн жагсаалтыг хавсаргав/	-	1	Албан шаардлага	2025.04.21 367	Аймгийн ГХБХБГ-ын дарга	Ч.Отгонжаргал
7	ХХААХҮС-аас 2024 онд эрх шилжүүлсэн 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих "Бяслаг" тоног төхөөрөмж ангиллаар батлагдсан төсөл, арга хэмжээг сандвичин барилга барихаар өөрчилж, ажлын даалгаврыг баталж үнэлгээний хороонд хүргүүлэн барилгын ажлын төндөрийн баримт бичиг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.38.2, 4.8.38.4 заасныг зөрчсөн байна.	698.80	1	Хариуцлага тооцох албан шаардлага	2025.04.21 364	Архангай аймгийн засаг дарга	Б.Цэрэннадмид
Төлбөрийн актын дүн		6,164.20	6				
Албан шаардлагын дүн		20,424.90	1				
Зөвлөмжийн дүн		26,589.10	7				
НИЙТ ДҮН							